



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БАГА БОЛОВСРОЛ



МОНГОЛ ХЭЛ

БАГАНАН КОД
НААХ ХЭСЭГ

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

Эхийг уншаарай.

Бичиг мэддэггүй бамбарууш

Ойн нарлаг чөлөөнд зараа, туулай хоёр хамт амьдардаг байжээ. Нэгэн өдөр зараа жимсэнд явж, туулай гэртээ үлджээ. Туулай хачиртай, том том бин хайрч дуусаад, тоглохоор гарав. Үүдээ цоожлоод, түлхүүрээ харин түлээн доогуур нуулаа”. Зараа найз минь, Түлээн доогуур түлхүүр бий. Би жаахан тоглочоод ирье. Бингээ идээд амарч байгаарай. <<Туулай>> гэж бичээд цоожны нүхэнд шургуулав.



Туулайг яваад удаагүй байхад хачиртай бингийн үнэр авсан бамбарууш ирлээ. “Энэ одоо юун бичиг вэ? Би ямар уншиж мэдэх биш” хэмээн ганцаараа ярьж байтал гавар гарч ирэв. Гавар бичгийг нүдээ эргэлдүүлэн уншиж байснаа гэнэт бачимдсан дүр үзүүлэн - “Арван хормын дараа энэ байшин дэлбэрнэ” гэж бичсэн байна. Бамбарууш туулайг хараад “Танай.... Танай....байшин....байшин дэлбэрэх” гэж байна хэмээн хашхирав. Туулай, гэрийн зүг ухаангүй дэгдлээ. Бамбарууш араас нь “Ойртож болохгүй! Очиж болохгүй! “гэж хашхиран гүйж яваад бүдэрч унав. Хэвтэж хэвтэж босоод харвал, том бин амандаа зуусан гаврыг хайруулын таваг гартаа барьсан туулай элдэж яваа харагдав. Бамбарууш сая л гаварт хууртагдсанаа мэдэж “Бичиг үсэг сураагүйдээ” гэмшиж гэнэ.

О.Сундуй

1 Баатрын болон зохиогчийн хэлсэн үгийг ялгаж тэмдэглээрэй.

Эхийн хэсгээс	баатрын үг	зохиогчийн үг
...Нүдээ эргэлдүүлэн уншиж байснаа гэнэт бачимдсан дүр үзүүлэн...		
...Энэ одоо юун бичиг вэ? Би ямар уншиж мэдэх биш...		

2 “Түлээн доогуур түлхүүр бий. Би жаахан тоглочоод ирье. Бингээ идээд амарч байгаарай. <<Туулай>> гэж бичээд цоожны нүхэнд шургуулав” гэсэн хэсгээр туулайн ямар зан чанарыг илэрхийлсэн бэ?

А. нөхөрсөг Б. гэнэн В. тусч Г. хөдөлмөрч

3 Гавар яагаад “Арван хормын дараа энэ байшин дэлбэрнэ гэж бичсэн байна” хэмээн хэлсэн бэ?

.....
.....



4 А. Чухал гэж бодсон өгүүлбэрээ гэж тэмдэглээрэй.

Зараа найз минь,
Түлээн доогуур
түлхүүр бий. Би
жаахан тогlochоод
ирье.

Бамбарууш туулайг
хараад, “Танай....
Танай....байшин....
байшин дэлбэрэх гэж
байна” гэж хашхирав.

Бамбарууш сая л
гаварт хууртагдсанаа
мэдэж “Бичиг үсэг
сураагүйдээ” гэмшиж
гэнэ.

Б. Яагаад чухал гэж бодсоноо бичнэ үү.

.....
.....

5 ..Бамбарууш араас нь “Ойртож болохгүй! Очиж болохгүй! “гэж хашхиран гүйж яваад
бүдэрч унав. “Туулай энэхүү бамбаруушийг хараад юу гэж хэлэх байсан бол”
хэмээн төсөөлөн бодоод бичээрэй.

.....
.....
.....

6 Тохирох үгсийг ялган бичээрэй.

бодож, нимгэн,
самбар, утас



Балархай эгшиг нь эгшигт гийгүүлэгчийг эгшигжүүлсэн үг:

.....
.....



7

“Бичиг мэдэхгүй бамбарууш” зохиолыг уншаад, төрсөн сэтгэгдлээ бичнэ үү.
(Үгийн тоо:40 – 45)

Эхлэл хэсэг: Чамд төрсөн сэтгэгдлээ бичнэ.

Гол хэсэг: Сэтгэгдлийг батлах жишээ зохиолоос олж бичнэ.

Жишээ 1

Жишээ 2

Төгсгөл хэсэг: Өөрийн үгээр дүгнэн бичнэ.



Засалтын хүснэгт

Даалгаврын дугаар	Авсан оноо	
I		
II		
III		
IV		
V		
VI		
VII	A	
	Б	
	B	

